



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/34

Арвайхээр сум

“Суралцагчийн эрхийг хамгаалах  
дэд хөтөлбөр” батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.3, 23.4, 23.11 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.3.3, 33.3.4 дэх заалт, “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.4, 14.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагчдад хүүхэд хамгаалал, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, тэдний хөгжил, оролцоо, аюулгүй байдлыг хангах, суралцах таатай орчныг бүрдүүлэх “Суралцагчийн эрхийг хамгаалах дэд хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сургалтын албаны менежер (С.Уртнасан)-т, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам өөрийн үнэлгээ хийж, захирлын зөвлөлд танилцуулж ажиллахыг Чанарын баталгаажилт, дотоод хяналтын менежер (Б.Хуягмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төлөвлөлтийг үнэн зөв төлөвлөж ажиллахыг Сургалтын албаны менежер(С.Уртнасан)-т, шаардагдах төсвийг төсвийн зохих зүйл ангиас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Хандсүрэн)-д даалгасугай.



ЗАХИРАЛ  С.САНЧИР

## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН “СУРАЛЦАГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын ерөнхий хууль, “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Алсын хараа-2050, сургуулийн захирлын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын бодлого”-ийг тус тус үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

“Суралцагчийн хөгжил хамгаалал” дэд хөтөлбөр 2020-2024 онд хэрэгжиж, хэрэгжилтэд хийсэн хяналт- шинжилгээ үнэлгээгээр 70 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн.

Зөвлөмжийн дагуу хөтөлбөрийг шинэчлэн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөн, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхой тусган, хэрэгжилтийн хувь, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга түүнтэй уялдуулан боловсруулсан сургуулийн захирлын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын бодлого”-той нийцүүлж, эцэг эх, багш, суралцагчдын хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлж, мэргэжлийн боловсрол сургалтын бодлогын хэрэгжилтийг хүүхэд хамгаалал, хөгжил оролцоог хангах, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх хүрээнд хөтөлбөрийг боловсруулах нийтлэг үндэслэл болж байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Суралцагчдад хүүхэд хамгаалал, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, тэдний хөгжил, оролцоо, аюулгүй байдлыг хангах, суралцах таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

### Гурав. Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Суралцагчдад урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэж, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.2. Суралцагч нэг бүрийн өсөлтийн сэтгэлгээ, бүтээлч үйлийг дэмжин, тэдний оролцох, хөгжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 3.3. Суралцагчдын сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, сэтгэл зүйн ганцаарчилсан, бүлгийн зөвлөгөө, тусламж үзүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулна.
- 3.4. Суралцагч нэг бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дадал, чадварыг эзэмшүүлнэ.
- 3.5. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурах үйл явцад нь дэмжлэг үзүүлэх, сургууль, дотуур байрын орчинд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

## **Дөрөв. Хөтөлбөрийн зарчим**

4.1. НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын ерөнхий хууль, "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн газрын Алсын хараа-2050, сургуулийн захирлын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлого" болон холбогдох бусад бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх

4.2. Хөтөлбөрөөр дамжуулан суралцагч бүрийн хүүхэд хамгаалал, хөгжил оролцоог хангах, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, суралцагчдын эрхийг хамгаалсан, тэдний хүсэл сонирхол хэрэгцээнд нийцүүлсэн байх

## **Тав. Хөтөлбөрийн хугацаа**

5.1. Хөтөлбөрийг 2025-2028 оныг дуустал хэрэгжүүлнэ.

## **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

### **Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.1. Суралцагчийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэх

6.1.1. Суралцагчдад хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах

6.1.2 Суралцагчдын учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх багш айлчлалын программыг боловсронгуй болгож, судалгааны мөрөөр ажиллан, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх

6.1.3 Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, хариу арга хэмжээ авах

6.1.4 Хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээг хүргэх

6.1.5. Сургууль, дотуур байранд хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг ажиллуулах


6.1.6. Сургалтын орчинд хүүхдэд учирч болзошгүй гөхцөл байдал, байгууллагын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийх ажлыг жилд 1 удаа зохион байгуулж, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх

6.1.7. Суралцагчдын өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг үр дүнтэй зохион байгуулах

6.1.8. Гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудад холбон зуучлах

6.1.9. Багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хүүхдийн эрх, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга эзэмшүүлэх талаар сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, зөвлөгөө өгөх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах

### **Зорилт 2-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**



6.2. Суралцагч бүрийн хөгжил, оролцох эрхийг дээдлэн, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хичээлээс гадуурх арга хэмжээг зохион байгуулах

6.2.1. Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сонирхлын бүлгийг дэмжих, клуб, дугуйлангийн хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх

6.2.2. Хүүхдийн болон тэдний төлөөллийн байгууллагын саналыг сонсох, хүүхдийн оролцоог хангаж тэдний санал, санаачилгыг дэмжин ажиллах

6.2.3. Суралцагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх

6.2.4. Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг орон нутгийн соёл, урлагийн байгууллага болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

6.2.5. Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулах

6.2.6. Хүүхдийг суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалт, үйл ажиллагаанд хамруулах

**Зорилт 3-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.3 Суралцагчдыг сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэл зүйн зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө тусламж үзүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах

6.3.1. Сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

6.3.2. Хүүхдийн сэтгэцийн процесс, сэтгэцийн шинж, нийгэмших үйл явц, харилцаа, хандлагыг үнэлж, оношилгоо хийх, дүгнэлт гаргах

6.3.3. Тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг үнэлж, оношлох, ажиллах арга барилыг тодорхойлох

6.3.4. Хүүхдийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зан үйлийн эрсдэл, бэрхшээлийг оношлох, илрүүлэх, багш ажилчид, үе тэнгийхэн, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй ажиллах арга барилыг тодорхойлж, зөвлөн тусалж ажиллах

6.3.5. Хүүхдэд гэр бүл, сургууль, үе тэнгийхэн болон орчноос үзүүлж буй нөлөө, хүчин зүйлийг илрүүлж, шалтгаан, үр дагаврыг тодорхойлж, засаж залруулж, санал зөвлөмж боловсруулж ажиллах

6.3.6. Суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг зохион байгуулж, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх

6.3.7. Хүүхдийн өөрийгөө болон бусдыг таньж мэдэх, зан үйл, сэтгэл хөдлөлөө удирдах, нийгэмших чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах

6.3.8. Багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүй, нийгэмших үйл явцын онцлог, хүүхэдтэй харилцах арга барил зэрэг сэтгэл зүйн боловсрол олгох сургалт зохион байгуулах

6.3.9. Суралцагчдын авьяас чадвар, бүтээлч үйлийг хөгжүүлэхэд сэтгэц, нийгэмших үйл явцтай харьцуулан багш, эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх

**Зорилт 4-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.4. Үйлдвэрлэлийн дадлагад гарахын өмнө болон дадлагын явцад хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилсан зааварчилгаа өгөх, гарын авлагаар хангах;

6.4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аянг өрнүүлж, зохион байгуулах

6.4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой арга хэмжээнүүдийг тогтмол зохион

6.4.3. Гамшгийн үед өөрийн болон бусдын амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах мэдлэг, чадвар олгох, дадлага сургалтыг зохион байгуулах

6.4.4. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийн сургалтын орчны аюулгүй байдлыг ханган ажиллах

6.4.5. Анги хамт олны дунд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сэдэвт сургалт, хэлэлцүүлэг, уралдаан, тэмцээн, аяныг зохион байгуулах

### **Зорилт 5-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.5. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурах үйл явцад нь дэмжлэг үзүүлэх, сургууль, дотуур байранд эзлтэй орчныг бүрдүүлэх

6.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог ялгаатай байдлыг дэмжсэн тусгайлан модуль хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

6.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч, мэдээллийг нэгтгэх

6.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх

6.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг клуб дугуйланд хамруулах, тэдний хөгжил, оролцоог дэмжих

6.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх зэрэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах



**Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.**

**Зорилт 1.** Суралцагчийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэх

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Хамтран зохион байгуулагч
		Үзүүлэлт	2025	2026	2027	2028	
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хүүхэд бүр хүндтэй" нөлөөллийн аяныг зохион байгуулах	Хүүхэд хамгааллын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд жил бүр 10-аас дээш арга хэмжээнд 600 гаас доошгүй суралцагчийг хамруулсан байна.	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 500-650 суралцагч	10 доошгүй арга хэмжээ	14 доошгүй арга хэмжээ	15 доошгүй арга хэмжээ	18 доошгүй арга хэмжээ	ГБХХгазар, Цагдаагийн газар, Насан туршийн боловсролын төв, ГХУСАЗСЗөвлөл
			600-700 суралцагч	700-750 суралцагч	750-850 суралцагч	850-900 суралцагч	
Суралцагчдын учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх "Багш айлчлал" программыг боловсронгуй болгож,	"Багш айлчлал" аргачлалыг хэрэгжүүлж анги удирдсан багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх	"Багш айлчлал" аргачлалыг хэрэгжүүлж 200-300 ар гэрт зочилсон байна.	2025	2026	2027	2028	Өвөрхангай аймгийн боловсролын газар Сургалтын алба, Сургуулийн хүүхэд хамгааллын баг
			Гэртээ болон байранд айлд, түрээсийн байранд амьдардаг суралцагчды	Гэртээ болон байранд айлд, түрээсийн байранд амьдардаг суралцагчдын 80%	Гэртээ болон байранд айлд, түрээсийн байранд амьдардаг суралцагчдын 90%	Гэртээ болон байранд айлд, түрээсийн байранд амьдардаг суралцагчдын 90%	



судалгааны мөрөөр ажиллах			н 80%				
Сургууль болон дотуур байранд хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг ажиллуулах	Тухай бүрд санал хүсэлт, гомдол мэдээллийг бичгээр болон амаар, хүлээн авч шийдвэрлэн ажиллана.	Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээж авсан 23 мөрөөр нь ажилласан 9 арга хэмжээнд 400-500 суралцагч хамрагдсан	Тухай бүрд нь гомдол мэдээлэл хүлээн авч санал хүсэлтийн дагуу ажиллана.	Тухай бүрд нь гомдол мэдээлэл хүлээн авч санал хүсэлтийн дагуу ажиллана	Тухай бүрд нь гомдол мэдээлэл хүлээн авч санал хүсэлтийн дагуу ажиллана	Тухай бүрд нь гомдол мэдээлэл хүлээн авч санал хүсэлтийн дагуу ажиллана	Хүүхэд хамгааллын баг, Сургалтын алба
Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад кейс, менежмент, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, хариу арга хэмжээ авах	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна.	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай 7 суралцагчдад үйлчилгээ үзүүлсэн.	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажиллана	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажиллана.	Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.	Хүүхэд хамгааллын баг, Сургалтын алба



Эцэг эх, асран хамгаалагч нарт өдөр тутмын зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх, хамтран ажиллах	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг хүргэн хамтран ажилласан байна.	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөн туслах үйлчилгээг 63 асран хамгаалагч нарт өгсөн.	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг хүргэнэ	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг хүргэнэ.	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг хүргэнэ.	Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөх үйлчилгээг хүргэнэ.	Хүүхэд хамгааллын баг, Сургалтын алба
"Хорт зуршил бидний зуршил биш" хорт зуршилгүй ирээдүйг бүтээх талаар мэдлэг ойлголтыг түгээх нөлөөллийн ажил	Хорт зуршил хэрхэн эрүүл мэндэд хор нөлөө үзүүлдэг болох талаар мэдлэг ойлголтыг түгээсэн Жил бүр 4-өөс дээш нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулан 500-аас доошгүй суралцагчийг хамруулсан байна.	Сургалт, нөлөөллийн арга хэмжээг 600 суралцагчдад тогтмол зохион байгуулав	4 доошгүй арга хэмжээ	6 доошгүй арга хэмжээ	8 доошгүй арга хэмжээ	9 доошгүй арга хэмжээ	ГБХХгазар, Цагдаагийн газар, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш
			500-600 суралцагч	600-650 суралцагч	650-700 суралцагч	700-850 суралцагч	
"Өдөр тутам хэрэглэх	Жил бүр 2-доошгүй арга	310 багш, ажилтан, эцэг	2 доошгүй арга хэмжээ	2 доошгүй арга хэмжээ	2 доошгүй арга хэмжээ	3 доошгүй арга хэмжээ	Сургалтын алба, нийгмийн ажилтан,



хүмүүжлийн эерэг арга" сэдэвт сургалт семинарыг багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч нарт зохион байгуулах	хэмжээнд 300-аас дээш багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна.	эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчдийг хамруулан ажиллав.						сэтгэл зүйч, дотуур байрын багш
Суралцагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх	Жилд 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна.	787 суралцагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, 2282 суралцагчдад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн.	2 урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ	2 урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ	2 урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ	2 урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ		БОЭТ, ЭМГ, "Нарны дөш" ӨЭМТ
			200 суралцагч	220 суралцагч	250 суралцагч	270 суралцагч		
Суралцагчдад эрүүл мэнд, эрүүл аж төрөх талаар сургалт мэдлэг мэдээлэл хүргэх	Жил бүр 3-аас доошгүй удаагийн сургалт мэдээлэлд хамруулсан байна.	Эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтад 1431 суралцагчдыг хамруулсан.	3 сургалт сурталчилгаа	3 сургалт сурталчилгаа	3 сургалт сурталчилгаа	3 сургалт сурталчилгаа		БОЭТ, ЭМГ, "Нарны дөш" ӨЭМТ, бусад мэргэжлийн байгууллагууд
			300 суралцагч	320 суралцагч	330 суралцагч	350 суралцагч		



<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх</p>	<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг сургуулийн дотоод, гадаад орчинд жил бүр тогтмол хийж, түүний дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж үр дүнд хүрсэн байна.</p>	<p>Сургуулийн дотуур байранд эрсдлийн үнэлгээ хийсэн.</p>	<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийж, анализ хийж нэгтгэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийж, анализ хийж нэгтгэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийж, анализ хийж нэгтгэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Сургалтын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийж, анализ хийж нэгтгэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Хүүхэд хамгааллын баг, ХАБЭА-н зөвлөл</p>
<p>Дотуур байрын суралцагчдын "Охидын хөгжлийн өрөө" тохижуулах</p>	<p>Охидын хүсэл сонирхолд нийцсэн, тайван, дулаан, уур амьсгал бүхий охидод тохирсон, үзэмжтэй, бүтээлч орон зай бий болгосон байна.</p>	<p>Тусгайлсан охидод зориулсан "Охидын хөгжлийн өрөө" байхгүй.</p>	<p>Олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудад төсөл хөтөлбөр бичиж, санхүүгийн дэмжлэг авсан байна.</p>	<p>Олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудад төсөл хөтөлбөр бичиж, санхүүгийн дэмжлэг авсан байна.</p>	<p>Олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудад төсөл хөтөлбөр бичиж, санхүүгийн дэмжлэг авсан байна.</p>	<p>Олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудад төсөл хөтөлбөр бичиж, санхүүгийн дэмжлэг авсан байна.</p>	<p>Захиргаа аж ахуйн алба, Сургалтын алба</p>



**Зорилт 2.** Суралцагч бүрийг хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хичээлээс гадуурх арга хэмжээг зохион байгуулах

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Хамтран зохион байгуулагч
		Үзүүлэлт	2025	2026	2027	2028	
ХӨУБ, клуб, дугуйлангийн тоо, суралцагчдын тоог	Жил бүр 15-18 төрлийн клуб, дугуйлан, секц, сайн дурын оролцооны клубд 550 суралцагч хамруулсан байна.	17 төрлийн клуб, дугуйлан, секц, сайн дурын оролцооны клубд 550 суралцагч	17 төрлийн дугуйлан, секц, сайн дурын оролцооны клуб	17 төрлийн дугуйлан, секц, сайн дурын оролцооны клуб	18 төрлийн дугуйлан, секц, сайн дурын оролцооны клуб	19 төрлийн дугуйлан, секц, сайн дурын оролцооны клуб	Чиглүүлэгч багш нар, төрийн ба төрийн бус байгууллага
			550 суралцагч	550 суралцагч	570 суралцагч	600 Суралцагч	
"Нээлттэй зүрхнэг ирээдүй" хүүхдийн чуулга уулзалтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулах	"Мэргэжлийн боловсрол-бидний сонголт" хүүхдийн чуулга уулзалтыг зохион байгуулснаар хүүхдийн оролцоо эрхийг дээдлэн тэдний үзэл бодлыг сонсож, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн	Хүүхдийн чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж, тэдний дуу хоолойг сонсох чиглэлээр хийж хэвшээгүй.	Чуулга уулзалтад мэргэжлийн болон техникийн боловсролын 400-с дээш суралцагчдыг хамруулсан байна.	Чуулга уулзалтад мэргэжлийн болон техникийн боловсролын 400-с дээш суралцагчдыг хамруулсан байна.	Чуулга уулзалтад мэргэжлийн болон техникийн боловсролын 400-с дээш суралцагчдыг хамруулсан байна.	Чуулга уулзалтад мэргэжлийн болон техникийн боловсролын 400-с дээш суралцагчдыг хамруулсан байна.	Сургалтын алба, Өвөрхангай аймгийн Боловсролын газар, ХГБХХГ



	байна.						
Суралцагчдын дунд зохион байгуулах урлагийн арга хэмжээ зохион байгуулах	Жилд 5-аас доошгүй удаагийн арга хэмжээнд 400-аас дээш суралцагчид хамруулсан байна.	20 арга хэмжээнд 1550 /давхардсан тоогоор/ суралцагч хамруулсан.	5 арга хэмжээ	5 арга хэмжээ	6 арга хэмжээ	6 арга хэмжээ	Өвөрхангай аймгийн соёл урлагийн байгууллагууд
			400 суралцагч	500 суралцагч	550 суралцагч	600 суралцагч	
Суралцагчдын дунд зохион байгуулах спортын тэмцээн уралдаан зохион байгуулах	Жилд 4-аас доошгүй удаагийн арга хэмжээнд 300-аас дээш суралцагчид хамруулсан байна.	17 арга хэмжээнд 1320 /давхардсан тоогоор/ суралцагч	4 арга хэмжээ	5 арга хэмжээ	6 арга хэмжээ	6 арга хэмжээ	Өвөрхангай аймгийн биеийн тамир спортын газар, Төрийн ба төрийн бус байгууллагууд
			300 суралцагч	350 суралцагч	400 суралцагч	450 суралцагч	
Хүүхдэд байгаль орчноо хайрлах,	Жилд 2-аас доошгүй удаагийн арга	9 арга хэмжээнд 970 /давхардсан	2 арга хэмжээ	2 арга хэмжээ	3 арга хэмжээ	4 арга хэмжээ	Өвөрхангай аймгийн соёл,



үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах	хэмжээнд 300-аас дээш суралцагчид хамруулсан байна.	тоогоор/ суралцагч	400 суралцагч	500 суралцагч	600 суралцагч	700 суралцагч	урлагийн байгууллагуу Д
Цахим номын сангийн фонд бүрдүүлэх	Мэргэжлийн танин мэдэхүй, уран зохиолын 100 ширхэг цахим номтой болсон байна.	Цахим номын фонд байхгүй	25 цахим ном	25 цахим ном	25 цахим ном	25 цахим	Захиргаа аж ахуйн алба, Сургалтын алба, номын санч
Нийт			13 арга хэмжээнд, 2050 суралцагч	14 арга хэмжээнд, 2300 суралцагч	17 арга хэмжээнд, 2520 суралцагч	18 арга хэмжээнд, 2750 суралцагч	

**Зорилт 3.** Суралцагчдыг сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө тусламж үзүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Хамтран зохион байгуулагч
		Үзүүлэлт	2025	2026	2027	2028	
Сэтгэл зүйн ганцаарчилсан	Жил бүр суралцагчдын	Ганцаарчилсан сэтгэл зүйн	40-50	50-55 хувь	55-60 хувь	60-70 хувь	ХГБХГазар, Боловсролын



болон бүлгийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх	40-ээс дээш хувьд нь сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан байна.	зөвлөгөөг 48 суралцагчид, бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөнд 249 суралцагч хамруулсан.	хувь				газар
			400-аас доошгүй суралцагч	450-аас доошгүй суралцагч	500-аас доошгүй суралцагч	550-аас доошгүй суралцагч	
Сэтгэл зүйн сорил, судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас оношилгоо гаргуулахад хамтран ажиллах	Жил бүр суралцагчдын 50-аас дээш хувийг сэтгэл зүйн сорил, судалгаа, оношилгоонд хамруулсан байна.	Сэтгэл гутрал, зан үйлийн эрсдлийг илрүүлэх сорилоор 18 ангийн 556 суралцагчдыг хамруулан үр дүнг нэгтгэн боловсруулан, багш нарт зөвлөмж хүргэн ажиллав.	50-55 хувь	55-60 хувь	60-70 хувь	70-75 хувь	БОЭТөв, ХГБХГ газар, Боловсролын газар
			500-550 суралцагч	550-600 суралцагч	600-700 суралцагч	700-750 суралцагч	
			8-10 суралцагч	8-10 суралцагч	8-10 суралцагч	8-10 суралцагч	
Суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгоход дэмжлэг үзүүлэн, мэргэжил сонголтод аргазүйн зөвлөгөө үзүүлэх	Өвөрхангай аймгийн ЕБС-ийн 9-р ангийн суралцагчдад мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	Өвөрхангай аймгийн ЕБС-ийн 9-р ангийн суралцагчдад мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэн ажилласан.	Зарга хэмжээ	4арга хэмжээ	4арга хэмжээ	4арга хэмжээ	Боловсролын Газар, Насан туршийн боловсролын Төв, НТҮСХАЗүйч
			680 суралцагч	780 суралцагч	780 суралцагч	780 суралцагч	



"Өөрөөрөө гэрэлтэе" сэтгэл хөдлөл, зан үйл нийгэмших чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	Сэтгэл зүйн боловсролыг алхам алхмаар сэтгэл зүйн шаталсан суралцагчдын 75-80 хувийг хамруулан зохион байгуулсан байна.	Сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх нь"сургалт "Зөөлөн ур чадвар" сэтгэл зүйн сургалтад 520 суралцагчийг хамруулсан.	75 хувь	80 хувь	85 хувь	90 хувь	Боловсролын Газар, ХГБХГазар,
			825 суралцагч	880 суралцагч	935 суралцагч	990 суралцагч	
Багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлог, хүүхэдтэй харилцах арга барилын талаар нөлөөллийн ажил зохион байгуулах	Суралцагчдын сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зан үйлийн эрсдэлийг эцэг эхчүүдэд танилцуулан тогтмол харилцаа холбоо үүсгэн ажилласан байна.	Багш, эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчид, суралцагчдын гурвалсан холбоог сайжруулан 310 асран хамгаалагчид, хамруулсан.	30 хувь	40 хувь	50 хувь	60 хувь	Боловсролын Газар, ХГБХГазар, Сургалтын алба, НТҮСХАЗ
			350 эцэг эх, асран хамгаалагчид, 120 багш ажилтан	460 эцэг эх, асран хамгаалагчид, 120 багш ажилтан	575 эцэг эх, асран хамгаалагчид, 120 багш ажилтан	690 эцэг эх, асран хамгаалагчид, 120 багш ажилтан	
Нийт			40-50 хувь	50-55 хувь	55-60 хувь	60-70 хувь	

**Зорилт 4.** Суралцагч нэг бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, ажлын байран дээр учирч болох болзошгүй эрсдлээс өөрийгөө хамгаалах чадварт суралцуулах

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Хамтран зохион байгуулагч
		Үзүүлэлт	2025	2026	2027	2028	
Суралцагчдийг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байх	Жилд 1 удаа гэнэтийн ослын даатгалд 100% хамруулсан байна.	3 жилтэй ангийн 700 гаруй суралцагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулсан.	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Сургалтын алба, Нийгмийн түншлэл
			710	720	730	740	
Суралцагчдын дадлагын тайлан хамгаалалт, улсын шалгалт, үйлдвэрлэлийн дадлагад ХАБЭА зааварчилгаа өгөх	Жилд 6-аас доошгүй удаа ХАБЭА өдөр тутмын болон давтан зааварчилгааг өгч ажилласан байна.	Мэргэжлийн боловсролын 1, 1.5, 3 жилтэй ангийн нийт 700 суралцагчдад ХАБЭА өдөр тутмын болон давтан зааварчилгааг өгч ажилласан.	6 удаа	6 удаа	7 удаа	7 удаа	Сургалтын алба, ХАБЭАБагш
			710 суралцагч	720 суралцагч	730 суралцагч	740 суралцагч	
Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ХАБ сарын аяныг зохиох	Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ХАБ сарын аяныг зохиох	Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ХАБ сарын аяныг зохиох	5 арга хэмжээ	6 арга хэмжээ	7 арга хэмжээ	7 арга хэмжээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах
			500 суралцагч, 100 багш ажилтан	650 суралцагч, 120 багш ажилтан	700 суралцагч, 120 багш ажилтан	700 суралцагч, 120 багш ажилтан	



байгуулах	байгуулан 5-аас дээш арга хэмжээнд 500 дээш суралцагч хамруулсан байна.	байгуулан 900 суралцагч хамруулсан.					ажилтан, ХАБЭА-н зөвлөл
Суралцагчдыг ажлын хувцас, тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Жилд 1-аас доошгүй мэргэжлийн ангиудын суралцагчдыг ажлын хувцас, тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан байна.	Уул уурхайн мэргэжлийн 167 суралцагчийг ажлын хувцас, хасгаалах хэрэгслээр хангасан.	1 удаа	1 удаа	1 удаа	1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл
			200 суралцагч	200 суралцагч	250 суралцагч	250 суралцагч	
Суралцагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад хамруулах	Жилд 4-өөс доошгүй Суралцагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад хамруулсан байна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 4 удаагийн сургалтад 500 суралцагч хамрагдсан	4 сургалт	4 сургалт	5 сургалт	5 сургалт	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл
			500 суралцагч	500 суралцагч	600 суралцагч	600 суралцагч	
Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийн	Жилд 10-аас доошгүй ажлын байранд	Дадлагын газрууд ажлын байранд	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	ХАБЭА-н зөвлөл, мэргэжлийн



сургалтын орчны аюулгүй байдлыг ханган ажиллах	хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийн сургалтын орчны аюулгүй байдлыг ханган ажилласан байна.	хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэн орчин нөхцөлийг сайжруулсан байна.					байгууллага
--	--	---	--	--	--	--	-------------

**Зорилт 5.** Тусгай хэрэгцээтэй суралцагчдын сурах үйл явцад нь дэмжлэг үзүүлэх, сургууль, дотуур байрын орчинд ээлтэй орчныг бүрдүүлэх

Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Хамтран зохион байгуулагч
		Үзүүлэлт	2025	2026	2027	2028	
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын оношлогооны магадлагааг авч, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эмнэлгээр магадлуулсан н оношлогоог нэгтгэж мэдээллийн санг бүрдүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын оношлогоог авч нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоогоор	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоогоор	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоогоор	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоогоор	БОЭТ, сургуулийн эмч
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ганцаарчилсан сургалтын	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хичээлийн судлагдахуун тус бүрээр	Тусгай хэрэгцээт суралцагчидтай ажиллах ганцаарчилсан сургалтын	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг судлагдахуун тус бүр	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг судлагдахуун тус бүр дээр хийж,	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг судлагдахуун тус бүр дээр хийж,	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг судлагдахуун тус бүр дээр хийж, сажруулалт хийж	Сургалтын алба



хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	боловсруулж ажилласан байна.	төлөвлөгөөг ерөнхий эрдмийн 11 судлагдахуун хичээлээр 6 төлөвлөгөө боловсруул сургалтандаа ашиглав.	дээр хийж, сажруулалт хийж ажиллана.	сажруулалт хийж ажиллана.	сажруулалт хийж ажиллана.	ажиллана.	
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн онцлогт тохирсон ном гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн онцлогт тохирсон ном гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй.	Дохионы хэл, брайль үсгийн ном 3-5 Ширхэгийг нэмэгдүүлэх	Гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн 5-7 ширхэгээр нэмэгдүүлэх	Гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн 5-7-10 ширхэгээр нэмэгдүүлэх	Гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн 10-15 ширхэгээр нэмэгдүүлэх	Сургалтын алба
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг клуб дугуйланд хамруулах	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг клуб дугуйланд тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг клуб дугуйланд 3 суралцагч хамрагдаж байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамрагдалтыг 15 хувиар нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамрагдалтыг 15 хувиар нэмэгдүүлэх	Сургалдтын алба
Хөгжлийн			1 орчин	1-2 орчин	1-2 орчин	1-2 орчин	



бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ээлтэй орчныг бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ээлтэй орчныг нэмэгдүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан налуу шат, 00-ийн тохижилт хийгдсэн	Ариун цэврийн өрөө тохижуулах	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Сургал алба Захиргаа ахуйн
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах төлөвлөгөө байхгүй.	15-20 эцэг эх асран хамгаалагчид	15-20 эцэг эх асран хамгаалагчид	20-25 эцэг эх асран хамгаалагчид	20-25 эцэг эх асран хамгаалагчид	Сургал алба



бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ээлтэй орчныг бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ээлтэй орчныг нэмэгдүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан налуу шат, 00-ийн тохижилт хийгдсэн	Ариун цэврийн өрөө тохижуулах	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлэх	Сургалтын алба, Захиргаа аж ахуйн алба
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаарх эерэг хандлагыг нэмэгдүүлэх, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах төлөвлөгөө байхгүй.	15-20 эцэг эх асран хамгаалагчид	15-20 эцэг эх асран хамгаалагчид	20-25 эцэг эх асран хамгаалагчид	20-25 эцэг эх асран хамгаалагчид	Сургалтын алба

### **Найм. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

8.1.1. Суралцагчийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй сургуулийн хүүхэд хамгааллын баг, мэргэжлийн байгууллага, эцэг эхтэй ажилласан байна.

8.1.2. Суралцагч нэг бүрийн өсөлтийн сэтгэлгээ, бүтээлч үйлийг дэмжин, тэдний оролцох, хөгжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.

8.1.3. Суралцагчдын сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, сэтгэл зүйн ганцаарчилсан, бүлгийн зөвлөгөө, тусламж үзүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулсан байна.

8.1.4. Суралцагч нэг бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дадал, чадварыг эзэмшүүлсэн байна.

8.1.5. Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын, сурах үйл явцад нь дэмжлэг үзүүлэх, сургууль, дотуур байрын орчинд ээлтэй орчныг бүрдүүлсэн байна.

### **Ес. Хөтөлбөрийн санхүүжилт**

9.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

9.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

9.1.2 Олон улсын болон төслийн байгууллага, төрийн бус байгууллага

9.1.3. Бусад эх үүсвэр

### **Арав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, мониторинг**

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд 1 удаа дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

11.2. Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн эцэст тайлагнах